



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2021 оны 1-р улирлын гүйцэтгэл

“ХЭЛДЭГ ГУРАВ, ХИЙДЭГ ГАНЦ”



Хэлдэг гурав, хийдэг ганц

Банк гурван хувийн зээл өгсөнгүй, банк ажилласангүй, банканд дээр очихоор өгөхгүй байна гэх иргэд, аж ахуйн нэгжийн санал, гомдол мэр сэр. Гэхдээ бид юмны наана, цааныг нь ухах хэрэгтэй.

“Хэлдэг гурав, хийдэг ганц” гэж зохиол байдаг даа. Яг цар тахлын үед бол хийдэг ганц нь банк болчихоод байна. Учир нь ЖДҮ-ийн 2 их наяд төгрөгийн хөтөлбөр, Репо санхүүжилтийн 2 их наяд төгрөгийн хөтөлбөрийг хурдан хугацаанд хэрэгжүүлж чадах дэд бүтэцтэй ганц газар нь банк юм.

Оны эхнээс л 10 их наяд төгрөгийн төлөвлөгөөний хүрээнд олгох зээлийн талаар эцсийн шийдвэр нь банканд дээр ирэхгүй удсан. Ийнхүү зээл олголт хийж эхлээд удаагүй байтал хөл хорио тогтоосон. Одоогийн байдлаар 1 их наяд гаруй төгрөгийн зээл цогц төлөвлөгөөний хүрээнд олгогдоод байна.

Гэхдээ энэ зээлийг хүссэн бүхэнд нь олгоод байна гэвэл бас үгүй. Дурын хүн нь аваад, зээлээ төлж чадахгүй нөхцөлд Зээлийн батлан даалтын сангаас гаргаад өгнө гэсэн баталгаа байхгүй. Тиймээс банк аль болох зээлээ төлөх чадвартай, тэр нь цаасан дээр баталгаажсан, бүр хэцүүдлээ гэхэд барьцаа хөрөнгийг нь авах иргэд, ААН-ийг л сонгоно гэсэн үг.

Яг хөтөлбөрийнхөө хувьд бол банканд ирж буй ашиг, үр өгөөж байхгүй. Харин нийгмийн хариуцлага, эдийн засгийг сэргээн босгоход хувь нэмрээ оруулж байгаа хэлбэр юм.


2021 оны 1-р улирлын байдлаар төгрөгийн хадгаламж жилийн 32 хувиар өссөн. Харин төгрөгийн харилцах 23 хувиар өссөн байна.

Валютын харилцах 2019 онтой харьцуулахад буурчээ. 2020 онд харилцахын хүү тэглэсэн, 2021 онд хугацаагүй хадгаламж тэглэхтэй холбоотой хугацаатай хадгаламж руу хөрвөсөн дүр зураг ажиглагдаж байна.

Их наяд ₮

Банкны эх үүсвэр, Жил бүрийн 1-р улирлаар харуулав

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар



Онолын
тодорхойлолт

Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

+32%

Төгрөгийн хадгаламж
жилийн 20 хувиар өссөн.

2021 оны 1-р
улирлын гүйцэтгэл

1

ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ БАНКНЫ САЛБАРЫН ОРЧИН

2021 оны 1-р улирлын гүйцэтгэл

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.


+3%

Зээлийн үлдэгдэл дунджаар 3 орчим хувиар өсөв.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний Статистикийн Хороо

2021 оны 1-р улиралд зээлийн үлдэгдэл жилийн 3 хувиар өсөв.

Хэдийгээр Монголбанк бодлогын хүүг 5 нэгж хувиар бууруулсан ч зээл хангалттай өсөөгүй. Гэсэн ч ЖДҮ-ийн 3 хувийн хүүтэй зээлийн нөлөөгөөр он гарсаар зээлийн үлдэгдэл өсөж эхлэв.




Иргэдийн зүгээс хадгаламжаа барьцаалж зээл ихээр авч байна.

ЖДҮ-ийн 3 хувийн хүүтэй зээл, репо санхүүжилт гэх мэт зээлийн нөлөөгөөр худалдаа, үйлчилгээ, боловсруулах салбарын зээл олголт нэмэгджээ.

Иргэдийн зээл олголт, жил бүрийн 1-р улирлаар харуулав

Тэрбум ₮



Бизнесийн зээл олголт, жил бүрийн 1-р улирлаар харуулав



Банкны шинээр олгосон ЗЭЭЛ

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.


+27%

Шинээр олгосон зээлийн хэмжээ 2021 оны эхний улиралд 27 хувиар өсөв.


Хэрэглээний чанаргүй зээлийн харьцаа өсөж байгаа нь өрхүүдийн нөхцөл байдал хүнд байгааг илтгэж байна.

Бизнесийн зээлийн хувьд, ХАА болон боловсруулах салбарын 3 зээл тутмын 1, барилгын салбарын 5 зээл тутмын 1 нь чанаргүйтэж байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн 1-р улирлаар харуулав



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн 1-р улирлаар харуулав



Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

11.5%

2021 оны 1-р улирлын байдлаар 10 зээл тутмын 1- нь чанаргүйтэж байна.

Банкны зээлийн хугацаа хэтрэлт

Жич: 16-90 хоног хүртэлх хугацаа хэтэрсэн зээлийг хэлнэ.


7.3%

2021 оны 1-р улирлын байдлаар нийт зээлийн багцын 7.3 хувь нь хугацаа хэтэрсэн байна.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний Статистикийн Хороо

2021 он гарсаар иргэдийн хугацаа хэтэрсэн зээл тасралтгүй өсөж байна.

2021 оны 7-р сараас тэтгэмжүүд зогсож, зээлийн чанарын ангилал хэвэндээ орох үед иргэдийн зээл чанаргүйтэх магадлал өндөр байна.




2021 оны 1-р улирлын байдлаар төгрөгийн хадгаламж жилийн 32 хувиар өссөн.
Мөн төгрөгийн харилцах 23 хувиар өсжээ.

Валютын харилцах 2019 онтой харьцуулахад буурсан. 2020 онд харилцахын хүү тэглэсэн,
2021 онд хугацаагүй хадгаламж тэглэхтэй холбоотой хугацаатай хадгаламж руу хөрвөсөн
дүр зураг ажиглагдаж байна.

Их наяд ₮

Банкны эх үүсвэр, Жил бүрийн 1-р улирлаар харуулав



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн
харилцах, хадгаламжийг хэлдэг.

+32%

Төгрөгийн хадгаламж
жилийн 20 хувиар өссөн.

Банкны системийн долларжилт

Жич: Хадгаламж болон зээлийн хэдэн хувийг валютын эх үүсвэр болон зээл бүрдүүлж байгааг тодорхойлдог.


27%

Эх үүсвэрийн долларжилт 2021 оны 1-р улирлын байдлаар 27 хувьтай байна.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний Статистикийн Хороо


2020 оны 9-р сараас эхлэн эх үүсвэрийн (хадгаламж, харилцах) долларжилт буурсаар 2019 оны түвшиндээ эргэж хүрэв.

Ам.долларын ханш сүүлийн 2 жил төгрөгийн эсрэг чангарсантай холбоотой валютаар зээл гаргах банкуудын сонирхол буурав. Улмаар нийт зээлд валютын зээлийн эзлэх хувь тасралтгүй буурчээ.



Зээлийн жигнэсэн дундаж хүү буурахгүй байгаа нь эдийн засгийг дэмжих төлөвлөгөөний зээлээс бусад банкуудын зээл олголт өсөхгүй байгаатай холбоотой.

2020 оноос хойш хадгаламжийн хүү 4 нэгж хувиар буурсан бол зээлийн хүү 1.2 нэгж хувиар буураад байна.



Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жиллэгдсэн дундаж хүүг хэлнэ.

6.9%

Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү хамгийн бага түвшиндээ хүрээд байна.

2

ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


2021 оны 1-р улирлын нөхцөл байдал: Гадаад орчин талаас түүхий эдийн үнэ сэргэж, гадаад секторын үзүүлэлт аажмаар сайжирч байна. Харин дотоод эдийн засаг 5 удаагийн хөл хориотой холбоотой хүнд нөхцөл байдалд байна.

Төлөв байдал: Дотооддоо вакцинжуулалт хийгдсэн ч эдийн засаг бүрэн хүчин чадлаараа ажиллах боломж бага байна. Цар тахлаас гадна ОТ-н далд уурхайн төслийн асуудал, хүлээгдэж буй бондын төлбөр, төсвийн орлогын бүрдэлт, банкны реформ, улс төрийн сонгууль гэх мэт маш олон сорилт энэ жил хүлээж байна.


2021 оны 1-р улиралд эдийн засаг 15.7 хувиар өсөв.

2020 оны 7-р сараас хойш уул уурхайн ногоон бүс зарласнаар жилийн 30 хувь уналттай байсан тус салбар оны төгсгөлд 9 хувиар агшлаа. Харин 2020 оны 11-р сард хийгдсэн хөл хорио нь уул уурхайн бус салбарт хүчтэй нөлөөлсөн бөгөөд тус салбаруудын уналт даамжирсан байна.


2021 оны 1-р улиралд эдийн засаг 15.7 хувиар өсөв.



2021 оны 1-р улиралд уул уурхайн салбар 34 хувь өсөв.




2021 оны 1-р улиралд уул уурхайн бус салбар 11 хувь өсөв.




2021 оны эхний улиралд экспорт жилийн 93 хувиар өсөөд байна.

- Зэс, нүүрс хэвийн явагдаж байгаа ч Гашуунсухайтад Ковидын тохиолдол илэрснээр дахин сар орчим хугацаанд экспорт саатахаар байна. Тухайн экспортын компаниудын зардал өсөж байна.
- Импорт идэвхжиж байгаа ч хязгаарлалт их байна. Тиймээс худалдааны тэнцэл ашигтай байна.


Экспорт жилийн 93 хувь өсөж,
2 тэрбум ам.долларт хүрэв.



Импорт жилийн 31 хувиар өсөж,
1.5 тэрбум ам.долларт хүрэв.




Худалдааны тэнцэл, жил бүрийн 1-р
улирал, сая \$




Ханш тогтворжиж байгаа ч нөгөө талдаа инфляц өсөх эрсдэлтэй байна.

- Гадаад худалдааны үзүүлэлт сайн байгаа, дотоодын эдийн засгийн идэвхжил бага байгаа нь ханш тогтвортой байх шалтгаан болж байна. Улмаар валютын нөөц 10 сарын импортыг хангах түвшинд ирэв.
- Гэсэн хэдий ч дотоодод хүнсний инфляц 8 хувь хүрч байгаа нь цаашид инфляц нэмэгдэх, улмаар бодлогын хүү 2022 оноос өсөх хүлээлттэй байна.


Ханш тогтворжив.



Валютын нөөц 4,9 тэрбум \$ болов.



Бодлогын хүү




Инфляц өсөхөөр байна.



2021 оны 1-р улирлын байдлаар төсвийн орлого 29 хувиар өссөн. Гэсэн хэдий ч төсвийн нөхцөл байдал хүнд байна.

2020 онд хэрэгжүүлсэн хөл хорио нь төсвийн орлого буурахад нөлөөлжээ. Харин цар тахлын үед авсан арга хэмжээ нь төсвийн зарлагыг огцом өсгөсөн. Жишээ нь, төсвийн зарлагын 39 хувь халамж, 20 хувь нь барилга байгууламжийн хөрөнгө оруулалт, 11 хувийг зээлийн төлбөр эзэлж байна.


Төсвийн орлого 29 хувь өсөв.



Төсвийн зарлага 16 хувь өсөв.



Төсвийн ашиг, алдагдал, тэрбум ₮



3

СИСТЕМИЙН НӨЛӨӨ БҮХИЙ
5 БАНКНЫ ҮЗҮҮЛЭЛТ


2021 оны 1-р улирлын гүйцэтгэл

2020 оны 1-р улирлын байдлаар, системийн нөлөө бүхий 5 банкнаас 1 банкны актив буурсан байна.

Хасбанкны актив 100 тэрбум төгрөгөөр буурсан бол бусад банкуудын актив тодорхой хэмжээгээр өсжээ. Хаан банк активгаа хамгийн их өсгөсөн байна.

Их наяд ₮

Банкны актив, Жил бүрийн эхний улирлаар харуулав




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

2020 оны 1-р улирлын байдлаар, системийн нөлөө бүхий 5 банкнаас 1 банкны зээл буурсан байна.


Хасбанкны зээл 300 тэрбум төгрөгөөр буурсан бол бусад банкуудын зээл тодорхой хэмжээгээр өссөн байна. Хаан банк зээлийн үлдэгдлээ хамгийн их өсгөсөн бөгөөд энэ нь хөтөлбөрийн зээлтэй холбоотой.

Их наяд ₮

Банкны зээлийн багц, Жил бүрийн эхний улирлаар харуулав




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан



Системийн нөлөө бүхий 5 банкны эх үүсвэр 2021 оны 1-р улирлын байдлаар өсөлттэй байна.


Банкны хадгаламжийн хүү буурсан хэдий ч иргэд, ААН-ийн банкны хадгаламжид итгэх итгэл хэвээр байна.




2020 оны 1-р улирлын байдлаар, системийн нөлөө бүхий 5 банкнаас Төрийн банкны чанаргүй зээлийн харьцаа бууралттай байна.

Төрийн банкнаас бусад банкуудын чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт өссөн дүр зурагтай байна. Хамгийн өндөр зээлийн чанаргүйдэлтэй нь Худалдаа Хөгжлийн банк байна.

Чанаргүй зээлийн харьцаа, Жил бүрийн эхний улирлаар харуулав



Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Банк нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг.

12%


Өөрийн хөрөнгийн хүрэлцээ үзүүлэлт

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний Статистикийн Хороо

Системийн нөлөө бүхий 5 банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтийг хангаж байна.

Хас, Төрийн банкнаас бусад банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ бага зэрэг буурсан дүр зурагтай байна. Гэсэн хэдий ч харьцаа үзүүлэлтүүдээ хангаж байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, Жил бүрийн эхний улирлаар харуулав




Эх сурвалж: Банкуудын тайлан

Системийн нөлөө бүхий 5 банк нь хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийг хангаж байна.

Цар тахал гарсантай холбоотой ЖДҮ-ийг дэмжих 3 хувийн хүүтэй зээл, репо санхүүжилт гэх мэт зээлээс бусад зээлийн олголт төдийлөн өсөхгүй байна. Улмаар бүх банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Хөрвөх чадварын харьцаа, Жил бүрийн эхний улирлаар харуулав



2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
Хаан			Голомт			ХХБ			Хас банк			Төрийн банк		

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

